



What do I need to know if my child is expelled?

Parent/carer information

Миний хүүхэд сургуулиас хөөгдсөн бол би юу мэдэж байх ёстой вэ?

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Сургуулиас хөөх арга хэмжээ гэж юу вэ?

Сургуулиас хөөх арга хэмжээ гэдэг нь сургуулийн захирал болон Боловсролын Манлайлал хариуцсан захирал тухайн сурагчид сургуулиас явахыг мөн буцаж ирэхгүй байхыг мэдэгдэж буй явдал юм. Сургуулиас хөөх шийдвэр гаргах хүртлээ сургуулийн зүгээс таны хүүхдэд дэмжлэг үзүүлэх бүхий л арга хэмжээг авсан байвал зохино.

Сургуулийн захирал сурагчыг дараах хоёр шалтгаанаар сургуулиас хөөх боломжтой. Үүнд:

- Сурагч зан авирын ноцтой үйлдэл гарган, уг сурагчийн зохисгүй үйлдэлд авсан арга хэмжээнүүд үр дүнд хүрэхгүй байх.
- Сурагч 17 буюу түүнээс дээш настай бөгөөд суралцах үйл ажиллагаанд оролцоогүй байх.

Сурагчийг сургуулиас хөөх шийдвэр гаргахаасаа өмнө уг хүүхдийн хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн сургуулийн зүгээс таны хүүхдийн суралцах үйл ажиллагаанд хэрхэн дэмжлэг үзүүлсэн тухайгаа сургуулийн захирал эргэцүүлэн дүгнэх болно.

Сургуулиас хөөх шийдвэр гаргахын өмнө сургуулийн захирал тантай холбогдон таны хүүхдийг сургуулиас хөөх тухай асуудал яригдаж байгааг мэдэгдэнэ. Улмаар сургуулиас хөөх тухай бичгэн мэдэгдлийг танд илгээж, таны хүүхдийг сургуулиас хөөхөд хүргэж буй шалтгаан, сургуулиас хөөгдвөл юу болох тухай тайлбарлах уулзалтанд та болон таны хүүхдийг ирэхийг урина. Та уг уулзалтанд өөрт тань [дэмжлэг үзүүлэх хэн нэгэнтэй](#) хамт ирж болно. Тэр хүн та болон таны хүүхдэд сэтгэл санааны болон практик тусламж үзүүлж болно.

Шийдвэрийг хүлээн авсаны дараа хичээлийн долоон өдрийн дотор та өөрийн хүүхдийг яагаад сургуулиас хөөх ёсгүй талаарх үндэслэлээ бичиж сургуульд өгөх ёстой. Сургуулийн захирал шийдвэр гаргахдаа уг тайлбар бичгийг харгалзан үзэх болно.

Хэрвээ миний хүүхэд сургуулиас хөөгдвөл юу болох вэ?

Тухайн сурагчийг сургуулиас хөөх тухай шийдвэрийг сургуулийн захирал болон Боловсролын Манлайлал хариуцсан захирал хамтран гаргана. Сурагчийг сургуулиас хөөх тухай шийдвэр гарснаас 24 цагийн дотор сургуулийн захирал тухайн сурагч болон түүний эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэн, мөн NSW мужийн Боловсролын Яаманд мэдэгдэл илгээнэ.

Хэрвээ таны хүүхэд 17-оос доош настай бөгөөд зан авирын шалтгаанаар сургуулиас хөөгдсөн тохиолдолд сургуулийн захирал хичээлийн 15 өдрийн дотор уг сурагчид шинэ сургууль олох эсвэл үргэлжлүүлэн суралцах бусад зохион байгуулалт бүхий орчинг олж өгөх ёстой.

Хэрэв таны хүүхэд 17-оос дээш настай бол та болон таны хүүхэд үргэлжлүүлэн суралцах эсвэл ажил хөдөлмөр эрхлэх арга замыг харгалзан үзвэл зохино.

Сургуулийн зүгээс надад ямар мэдээллийг өгч чадах вэ?

Юу болсон, яагаад болсон талаар нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг та сургуулиас асууж болно. Сургууль танд өөрийн гаргасан аливаа шийдвэрийн цаад учир шалтгаан, мөн ямар арга хэмжээ авах, танд ямар нэгэн асуудал гарвал яах ёстойг тайлбарлах ёстой байдаг.

Сургуулиас хөөх шийдвэрийг би давж заалдаж болох уу?

Болно. Хэрвээ та сургуулийн захирал болон Боловсролын Манлайлал хариуцсан захирлыг шударга бус шийдвэр гаргасан, холбогдох дүрэм журмыг мөрдөөгүй хэмээн үзвэл болно. [Давж заалдах тухай мэдээлэлтэй](#) танилцана уу.

[Хүүхдээ өмгөөлөх](#) тухай мэдээлэл авах боломж танд нээлттэй ба мөн [Сургуулийн Хүрээлэлд Баримтлах Дүрэм](#)-д сургуулиудтай харилцах арга замуудын тухай дурдсан байгаа.

Би хэрхэн гомдол гаргах вэ?

Хэрвээ та сургуулиас хөөх арга хэмжээ, гаргасан шийдвэр, эсвэл үзүүлсэн тусламж, дэмжлэгт гомдолтой байвал та [гомдол гаргах тухай](#) дэлгэрэнгүй мэдээллийг вэб хуудсаар зочлон аваарай.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.